



British School of Ulaanbaatar

Улаанбаатар дахь Бритиш сургууль

4.10 – Сургалтын төлбөр төлөх журам

Улаанбаатар дахь Бритиш сургууль нь төрийн бус, өмчийн ерөнхий боловсролын сургууль тул тус сургуульд суралцагчдын эцэг эх, асран хамгаалагчид нь боловсрол олгохтой холбоотой зохих сургалтын төлбөр бусад хураамжийг төлөх үүрэгтэй болно. Сургуулийн зүгээс ногдуулж буй төлбөр хураамжийг буцаан олгогдох болон буцаан олгогдохгүй гэж ангилах ба үүнд;

Буцаан олгогдохгүй төлбөр/хураамж	Буцаан олгогдох төлбөр/хураамж
- Сургалтын төлбөр (түхэйн хичээлийн жилийн суудал баталгаажуулах барьцааг оролцуулан) - Капитал Хөгжүүлэлтийн Төлбөр, сургуулиас гадуурх шалгалтын төлбөр (зөвхөн түхэйн хичээлийн жилийн тодорхой бүлгүүдэд зориулсан) - Бүртгэлийн хураамж (шинээр элсэгчид)	- Сургуулийн автобусын төлбөр - Үдийн хоолны төлбөр - Номын сангийн барьцаат хураамж - Бусад төлбөр хураамж (сургуулийн эмчийн үзлэг эмчилгээний төлбөр, дүрэмт хувцасны төлбөр, нэмэлт хөтөлбөр, арга хэмжээнүүд гэх мэт)

Эдгээр төлбөр хураамжуудын талаарх дэлгэрэнгүйг доорхоос харна уу. Сургуулийн зүгээс гарын үсэг зуран баталгаажуулсан гэрээ хийснээс бусад тохиолдолд бүх төлбөр хураамжууд нэхэмжлэлд дурдсан хугацаанд бүрэн төлөгдсөн байх ёстой.

Улаанбаатар дахь Британи сургуулийн сургалтын төлбөр нь хичээлийн жилийн түрш гурав хуваагдаж нэхэмжлэгдэх болно. Сургуулийн санхүүгийн хэлтсээс нэгтгэсэн нэхэмжлэлийг 7 сарын 20, 12 сарын 15 болон 3 сарын 15-ны өдрүүдэд (дээрх өдрүүд амралтын өдөр таарсан тохиолдолд өмнөх ажлын өдөрт) сурагчдын эцэг эх, асран хамгаалагчид руу цахим шуудангаар илгээнэ. Нэгдүгээр улиралд нийт төлбөрийн 50%, харин хоёр болон гуравдугаар улиралд тус бүр 25%-ийг төлнө. Дээрх төлбөр хураамжуудын төлсөн байвал зохих сүүлийн хугацаа нь хичээлийн улирал бүрийн эхний өдөр байна. (түхэйн хичээлийн жилийн заасан өдрүүдийг **4.2 дахь хэсэгт байгаа Хичээлийн жилийн хуанлинаас харна уу**).

Сургалтын төлбөрийг түхэйн өдрийн Монгол Банкны ханшаар тооцон төгрөгөөр (MNT) төлнө. Бүх төлбөрийг банкны гүйвүүлгээр шилжүүлсэн байх ёстой. Суралцагч бүр төлбөрийн гүйлгээг тусдаа хийсэн байх ёстой. Суралцагчийн бүтэн нэр, анги бүлэг болон төлбөрийн зориулалтыг банкны гүйлгээний утган дээр тодорхой бичсэн байх ёстой. Жишээ нь: Жон Смит, 6 анги, Улаанбаатар дахь Бритиш сургуулийн сургалтын төлбөр. Эцэг эхүүд төлбөр төлсөн баримтын хувийг дараах хаяг руу илгээнэ үү: finance@britishschool.edu.mn

Данс эзэмшигч: British School Mongolia			
Банк	Хас банк	Худалдаа хөгжлийн банк	Голомт банк
Дансны дугаар /төгрөг/	5000549428	415015175	1145105625
Дансны дугаар /ам.доллар/	5000549435	415015176	1145105626

Тухайн хичээлийн жилийн сургалтын төлбөрийн хэмжээг Төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоож, баталдаг бөгөөд тусад нь мэдээллэдэг. Улаанбаатар дахь Бритиш сургууль нь нэг хичээлийн жилийн хугацаанд мэдэгдэл хүргүүлэн сургалтын төлбөрийг нэмэх эрхтэй болно.

Бүртгэлийн хураамж

Шинээр элсэж буй суралцагч бүр бүртгэлийн хураамж болгон 150 ам.доллар төлөх бөгөөд энэ нь бүртгэлийн үйл явц болон үнэлгээний зардалд зарцуулагдана. Энэхүү буцаан олгогдохгүй хураамжийг бүх шинээр элсэгчид болон Сургуулиас гараад буцаж орж буй суралцагчид төлнө. Бүртгэлийн хураамжийг элсэлтийн үнэлгээ болон ярилцлагын өмнө төлсөн байх ёстой. Үнэлгээ болон ярилцлагын үр дүнгээс үл хамааран бүртгэлийн хураамж нь буцаан олгогдохгүй болохыг анхаарна уу. Илүү дэлгэрэнгүй мэдээллийг **4.11 – Элсүүлэх бодлого, элсэлтийн журам** хэсгээс харна уу.

Сургуулийн автобусны төлбөр

Сургуулийн зүгээс автобусны үйлчилгээг өдөрт хоёр удаа үзүүлдэг бөгөөд сургуулийн автобусаар зорчих эсэх нь сонголттой байна. Хэрэв эцэг эх хүүхдэдээ сургуулийн автобусны үйлчилгээг өдөр бүр авахыг хүссэн тохиолдолд Сургуулийн автобусаар үйлчлүүлэх хүсэлтийн маягтыг бөглөн, гарын үсэг зурж баталгаажуулсан эх хувийг **хичээлийн улирал эхлэхээс өмнө** эсвэл хагас жилийн бүртгэл эхлэхээс өмнө сургуулийн ресепшинд хүлээлгэн өгсөн байна. Сургуулийн автобусны төлбөрийг тухайн хичээлийн жил дэх сургуулийн өдрийн тоонд үндэслэн автобусны үйлчилгээ авсан суралцагч бүрээс нэхэмжилнэ. Сургуулийн автобусны төлбөрийг тухайн хичээлийн жил эхэлснээс хойш 14 хоногоос хэтрүүлэлгүй төлнө (эсвэл хагас жилээр элсэгчдийн хувьд нэхэмжилэхэд заасан хугацаанд).

Хэрэв Сургуулийн зүгээс суралцагчийг хүндэтгэн үзэх шалтгааны улмаас дараалласан таваас дээш өдөр хичээлд суухгүй байх бичгэн зөвшөөрөл олгосон тохиолдолд тэрхүү зөвшөөрөлд үндэслэн сургуулийн автобусны төлбөрийг хувь тэнцүүлэн буцаан олгож болно. Дараалласан тав болон түүнээс доош хоног хичээлдээ ирээгүй, тасалсан тохиолдолд буцаан олголт олгогдохгүй болно.

Үдийн хоолны төлбөр

Үдийн хоол үйлчилгээг сонгон үйлчлүүлсэн суралцагчид хичээлийн улирал бүрд ногдох төлбөрийг төлнө. Тухайн суралцагч үдийн хоол үйлчилгээнд хамрагдсан боловч идээгүй тохиолдолд төлбөрийг буцаан олгохгүй. Хэрэв Сургуулийн зүгээс суралцагчийг хүндэтгэн үзэх шалтгааны улмаас дараалласан таваас дээш өдөр хичээлд суухгүй байхыг зөвшөөрөн, бичгээр зөвшөөрөл олгосон тохиолдолд тэрхүү зөвшөөрөлд үндэслэн үдийн хоолны

төлбөрийг хувь тэнцүүлэн буцаан олгож болно. Дараалласан тав болон түүнээс доош хоног хичээлдээ ирээгүй, тасалсан тохиолдолд буцаан олголт олгогдохгүй болно.

Номын сангийн барьцаат хураамж

Сургуульд элсэхэд төлдөг 200 ам.долларын Номын сангийн барьцаат хураамж нь буцаан олгогддог хураамж болно. Энэхүү хураамж нь тухайн суралцагчийн Улаанбаатар дахь Британи сургуульд суралцах хугацаандаа номын сангийн номнуудыг хаяж гээх, гамгүй хэрэглэх зэрэг эрсдлүүдээс сэргийлэх зорилготой хураамж болно. Хэрэв номын сангийн барьцаат хураамжийг төлөөгүй тохиолдолд тухайн суралцагч номын сангаар үйлчлүүлэхийг хориглох, номын сангаас ном зээлж авах эрх үүсэхгүй байх зэрэг үр дагавартай болно.

Суралцагч сургуулиа төгсөх эсвэл сургуулиас гарахдаа сурах бичгүүд болон номын сангийн номыг буцаан өгөх бөгөөд эдгээр ном, сурах бичгүүд цэвэрхэн хэрэглэгдсэн гэж үзвэл бичгээр өгсөн хүсэлтэнд үндэслэн энэхүү хураамжийг буцаан олгоно. Номнуудыг хаяж гээсэн, гамгүй хэрэглэсэн тохиолдол бүр буцаан олгох мөнгөн дүнд нөлөөлөх болно гэдгийг анхарна уу.

Сургуулиас гадуурх шалгалтын төлбөр

Кембриж Олон Улсаас хэрэгжүүлдэг IGCSE-Бүрэн дунд боловсролын олон улсын гэрчилгээ, AS болон А-түвшний шалгалтуудад бэлдэх зэрэг хөтөлбөрүүд нь хичээлийн хөтөлбөрөөс гадуур хэрэгждэг тул нэмэлт төлбөр төлдөг. Түүнчлэн Сургууль бэлэн болсон шалгалтын материалуудыг дүгнүүлж, тэмдэглэгээ хийлгэхийн тулд Кембриж рүү илгээдэг бөгөөд үүнтэй холбогдон гарах шуудангийн үйлчилгээний стандарт хураамжийг суралцагч төлнө. Олон Улсын Кембриж-ийн зүгээс дээрх төлбөрүүдийг жил бүр тогтоодог тул Сургууль нийт зардлыг жил бүр үнэлэн, хоёрдугаар сард болдог шалгалтын бүртгэлээс өмнө суралцагчид болон эцэг эхчүүдэд хүргэдэг. Шалгалтын төлбөр нь өгч буй шалгалтын тоо, практик шалгалт эсвэл их хэмжээний курсын ажил хянуулахаар өгөх зэрэг тусгай шаардлагуудад үндэслэгдэх бөгөөд суралцагч бүрт илгээх нэхэмжлэх бүрд нарийвчлан тусгагдсан байна.

Дээрх төлбөрүүдийг 11, 12 болон 13 дахь ангийн сурагчдаас тогтмол авдаг хэдий ч, сурагч дахин суусан, эсвэл стандартаас өмнө эсвэл хойно шалгалт өгсөн тохиолдолд үүнтэй холбогдон гарах төлбөр хураамжийг төлүүлнэ.

Суудал баталгаажуулах барьцаа

Хичээлийн жил бүрийн Тавдугаар сард, эцэг эхчүүд хүүхдээ дараагийн хичээлийн жилд тус сургуульд сургах хүсэлтэй байгаагаа баталгаажуулан хүүхэд тус бүрд 500 ам.долларын “суудал баталгаажуулах барьцаа”-г төлдөг. Суудал баталгаажуулах барьцаа нь тухайн сурагчийн Улаанбаатар дахь Бритиш сургуульд орон тоотой болохыг баталгаажуулаад зогсохгүй дараагийн хичээлийн жилийн Сургуулийн төлөвлөгөөг гаргахад дэмжлэг болдог. Дээрх төлбөр нь дараагийн хичээлийн жилийн нэгдүгээр улирлын сургалтын төлбөрт тооцогдоно. Сургалтын төлбөрийг жилээр нь урьдчилан төлсөн тохиолдолд суудал баталгаажуулах барьцаа хураамж төлөх шаардлагагүй болохыг анхаарна уу. Суралцагч дараагийн хичээлийн жил эхлэхэд суудлаа баталгаажуулаагүй, өөрөөр хэлбэл хадгалуулсан

суудлаа хүлээн аваагүй эсвэл дараа нь Сургуулиас гарсан тохиолдолд суудал баталгаажуулах барьцаа төлбөрийг буцаан олгохгүй.

Сургалтын төлбөрийн хөнгөлөлт

- *Жилийн төлбөрөө эрт төлсний хөнгөлөлт:* Нэг хичээлийн жилийн төлбөрөө бүрэн төлсөн тохиолдолд доорх хөнгөлөлтүүдийг эдлэх эрхтэй болно. Долдугаар сарын нэгний дотор нэг хичээлийн жилийн төлбөрөө бүрэн төлсөн тохиолдолд 8%, Наймдугаар сарын нэгний дотор бүрэн төлсөн тохиолдолд төлбөрийн 3% тус тус хөнгөлнө. Эцэг эхүүд Сургуулийн санхүүгийн газартай холбогдон нэхэмжлэх авах болон төлбөрөө эрт төлөх талаар тохиролцож болно.
- *Нэг гэрийн хүүхдүүдийн хөнгөлөлт:* Хэрэв нэг гэр бүлийн хоёр болон түүнээс дээш тооны хүүхдүүд нэг хичээлийн жилд суралцах тохиолдолд дараах хөнгөлөлтүүдийг эдэлнэ:
 - Хоёр дахь хүүхэд – 5% хөнгөлөлт хоёр дахь хүүхдэд;
 - Гурав дахь хүүхэд болон дараагийн хүүхдүүд – 10% хөнгөлөлт гурав дахь болон дараагийн хүүхэд тус бүрт.

Энэхүү хөнгөлөлт нь тухайн гэр бүлийн хүүхдүүдийн аль нэг нь сургалтын төлбөрийн бусад хөнгөлөлт эдэлдэг тохиолдолд хамаарахгүй.

- *Байгууллагын хөнгөлөлт:* Тусдаа нийтлэгдсэн Сургуулийн байгууллагын багцыг үзнэ үү.

Хичээлийн улирлын үеэрх суралцагчийн элсэлт

- Суралцагч тухайн хичээлийн улирал эхэлснээс хойш ажлын хорь хоногт Сургуульд элсвэл тухайн улирлын сургалтын төлбөрийг бүрэн төлнө.
- Суралцагч тухайн хичээлийн улирал эхэлснээс хойш ажлын хорин нэг болон түүнээс дээш хоногт Сургуульд элсвэл төлбөрийг хувь тэнцүүлэн төлнө.
- Хичээлийн улирлын үргэлжлэх хугацаа болон бусад огноонуудтай танилцахыг хүсвэл сургуулийн вэбсайтэд тавигдсан хуанлийг харна уу.

Хугацаандаа төлөгдөөгүй төлбөр хураамжууд

- Хэрэв төлбөр хураамжууд нэхэмжлэхэд заасан хугацаанд төлөгдөөгүй тохиолдолд доорх арга хэмжээнүүдийг авах болно. Үүнд:
 - Төлбөр төлөх сүүлийн хугацаанаас хойш 14 хоног, төлбөр хоцроосны торгууль болгон хугацаа хэтэрсэн өдөр бүр нийт төлөгдөөгүй төлбөрийн 0.25%-тай тэнцэх хэмжээний торгууль ногдуулна.
 - Төлбөр төлөх сүүлийн хугацаанаас хойш 30 хоног өнгөрвөл, бичгээр гаргасан хүсэлт нь ТУЗ-ын даргын зөвшөөрлийг авснаас бусад тохиолдолд суралцагчийг хичээлүүдэд нь суулгахгүй. Төлбөрөө хугацаандаа төлөлгүй хугацаа хэтрүүлсний улмаас сургуулиас хасагдах болсон тохиолдолд сурагч болон түүний эцэг эх, асран хамгаалагч нь суралцсан хугацааны аливаа төлбөрөөс чөлөөлөгдөхгүй болохыг анхаарна уу.

- Эцэг эх, асран хамгаалагч төлбөр төлөх хугацааг хойшлуулах эсвэл өөрчлөх хүсэлт гарган Сургуулийн зүгээс уг хүсэлтийг албан ёсоор зөвшөөрсөн тохиолдолд, Сургууль дээр дурдсан хувь хэмжээгээр торгууль төлөхийг шаардах эрхтэй.

Төлбөр хураамж төлөөгүйн улмаас гарч болох үр дагаварууд

Аливаа төлбөр хураамжууд нь заасан хугацаанд төлөгдөөгүй тохиолдолд Сургуулийн зүгээс дараах арга хэмжээнүүдийг авна. Үүнд:

- Суралцагчийн тайлан/хувийн хэрэг, дүнгийн хуулбар болон сургуулийн/багшийн тодорхойлолтуудыг суралцагч, түүний төлөөлөгч болон гуравдагч этгээдэд олгохгүй байх, олгох хугацааг хойшлуулах;
- Сургуулийн дижитал үйлчилгээнүүд (цахим сургалт, Google classroom, цахим шуудан, эцэг эхүүдийн портал болон мэдээллийн сан зэргийг оролцуулан бусад дижитал үйлчилгээнүүд)-д нэвтрэх эрхийг хаах;
- Дараагийн хичээлийн жил эсвэл хичээлийн улиралд ахин элсэхийг зөвшөөрөхгүй байх;
- Суралцагчыг албан ёсоор Улаанбаатар дахь Британи сургуулийн нэг талын шийдвэрээр сургуулиас хасна.

Төлбөрөө төлөөгүйн улмаас Улаанбаатар дахь Бритиш сургуульд үргэлжлүүлэн суралцах боломжгүй болсон аливаа суралцагч зөвхөн төлөгдөөгүй төлбөр болон хуримтлагдсан торгуулийг бүрэн төлсөн тохиолдолд сургуульд үргэлжлүүлэн суралцаж болох юм. Энэ тохиолдолд тухайн суралцагчийг үргэлжлүүлэн суралцуулах эсэхийг Сургууль дангаар шийдвэрлэх бөгөөд хүчин төгөлдөр хэрэгжиж буй элсэлтийн журмыг дагаж мөрдөнө. **(4.11 – Элсүүлэх бодлого, элсэлтийн журмыг харна уу)**. Сурагчийн суралцаж байгаа эсэхээс үл хамааран төлбөр төлбөл зохих сүүлийн хугацаанаас **хуанлийн 60 хүртэлх хоногоор** хэтэрсэн, Сургуультай төлбөр төлөх талаар ямар нэгэн зөвшилцөл хэлэлцээр хийгээгүй тохиолдолд данс бүртгэлийг хууль ёсны өр барагдуулах байгууллагад илгээх болно. Хуримтлагдсан торгуулийг оролцуулан бүх төлбөр бүрэн төлөгдөх шаардлагатай. Дээрх тохиолдолд тухайн суралцагчийн төлсөн буцаан олгогдох төлбөр хураамж (дээр дурдсан)-ийг сургалтын төлбөрт суутган авах эрхийг Сургууль эдэлнэ.

Хичээлд яваагүй болон сургуулиас гарах үеийн буцаан олголт

Сурагч Сургуулиас гарах болсон тохиолдолд түүний эцэг эх энэ тухай бичгээр хүсэлт гарган, **хуанлийн 90 хоногоос багагүй хугацааны** өмнө Сургуулийн захиралд хүргүүлнэ.

- Хэрэв суралцагч Сургуулиас гарах тухай мэдэгдэл хүргүүлэхээс өмнө хичээлийн жилийн төлбөрийг бүрэн төлсөн тохиолдолд тухайн оюутны Сургуульд суралцсан өдрүүдэд нь хувь тэнцүүлэн үлдэгдэл төлбөрийг буцаан олгоно.
- Хэрэв Сургуулиас гарах тухай мэдэгдэл хүргүүлээгүй тохиолдолд буцаан олголт хийгдэхгүй. Хэрэв тухайн суралцагч төлбөрөө төлөөгүй боловч сургуулиас гарах хүртэлх хугацаанд суралцсан бол данс тооцоог хууль ёсны өр барагдуулах байгууллагад шилжүүлнэ.

- Сургуульд эсвэл үйчилгээ үзүүлдэг эрх бүхий гуравдагч этгээдэд сургалтын төлбөр, капитал хөгжүүлэлтийн төлбөр, гадны шалгалтын хураамж, боловсролын итгэмжлэлийн үнэлгээний хураамж, номын сангийн барьцаат хураамж, үдийн хоол болон сургуулийн автобусын төлбөр болон бусад төлбөр хураамжуудыг оролцуулан өр төлбөртэй суралцагч болон түүний төлөөлөлд сурагчийн тайлан/хувийн хэрэг, дүнгийн хуулбар болон сургуулийн/багшийн тодорхойлолтуудыг олгохгүй болно.

Хөл хорио болон давагдашгүй хүчин зүйл

Засгийн газрийн зүгээс бүх нийтийн хөл хорио зарласан эсвэл давагдашгүй хүчин зүйлийн нөлөөгөөр Сургуулийн үйл ажиллагааг түр зогсоох шаардлагатай болбол хөл хорьсон хугацаа болон боловсрол олгох боломжит байдал зэргээс шалтгаалан Сургууль төлбөр хураамжтай холбоотой дараах арга хэмээнүүдийг авч хэрэгжүүлнэ:

- Ажлын тав болон түүнээс цөөн хоногоор богино хугацаанд хаах (цаг агаарын таагүй нөхцөл байдал үүссэн гэх мэт)
 - Сургалтын төлбөрийн буцаан олголт хийгдэхгүй;
 - Дээрх хаалттай байх хугацаанд төлсөн үдийн хоол, сургуулийн автобусны төлбөр болон боловсролын итгэмжлэлийн үнэлгээний хураамж зэргийг хичээлийн дараагийн улирлын ижил төрлийн үйлчилгээнд шилжүүлэн тооцно.
- Ажлын тав хоногоос дээш хоногоор хаах:
 - Сургуулийн зүгээс хичээл сургалтыг цахимаар зааж байгаа тохиолдолд сургалтын төлбөрийн буцаан олголт хийгдэхгүй. Цахимаар хичээллэхээр шийдвэр гарсан бол сурагчийн интернет холболт эсвэл цахим хичээлийн ирцийн түвшин зэргээс үл хамааран заавал хэрэгжүүлнэ.
 - Сургуулийн зүгээс хичээлийг цахимаар заах боломжгүй тохиолдолд (томоохон хэмжээний байгалийн гамшиг гэх мэт) хаалттай байсан өдрүүдэд хувь тэнцүүлэн сургалтын төлбөрийн буцаан олголт хийгдэнэ.

Капитал хөгжүүлэлтийн хураамж

Капитал хөгжүүлэлтийн хураамж бол Төлөөлөн Удирдах зөвлөлөөс 2022 онд тогтоосон нийт суралцагчдын жил бүр төлбөл зохих хураамж юм. Энэхүү хураамжийг сурагчийн үр чадвар, туршлагыг нэмэгдүүлэх, улам сайжруулахын тулд хийгдэх хөгжүүлэлтүүдэд зарцуулна. Нэн тэргүүнд, Улаанбаатар дахь Бритиш сургуулийн төгсөгчид нь хамгийн сүүлийн үеийн технологи бүхий ямар ч ажлын байранд өрсөлдөх чадвартай болохыг баталгаажуулахын тулд сүүлийн үед ихэд дэлгэрээд байгаа Өөрийн төхөөрөмж (ухаалаг утас, компьютер гэх мэт)-ийг хичээлдээ хэрэглэх (2.16 – BYOD-bring your own device буюу Өөрийн төхөөрөмжийг хичээлд хэрэглэх) болон бусад үйлчилгээнүүдэд шаардлагатай дэд бүтцийн хөгжүүлэлтийн санхүүжилтэд хэрэглэнэ. Дээрх орлогоор худалдан авсан бүх техник хангамж, програм хангамж, мэдээллийн сан болон бусад тоног төхөөрөмжүүд нь суралцагчийн мэдлэг, үр чадвар, туршлагыг нэмэгдүүлэхэд хэрэглэгдэнэ. Өөрийн төхөөрөмжийг хичээлд хэрэглэснээр сурагчид нь интернет ашиглан олж чадах эх сурвалжууд, цахим хичээлийн

шалгалт, сургалт хөтөлбөрүүд гэх мэт технологи, дижитал контент зэргүүд рүү сургуулиасаа болон гэрээсээ нэг төхөөрөмжөөс нэвтрэх боломжтой болно. Түүнээс гадна, Капитал хөгжүүлэлтийн хураамж нь сурагчийн сурлагын амжилтыг ахиулахад шаардагдах шинэчлэгдсэн болон шинээр гарч буй технологийг худалдан авах, суурилуулах болон засвар үйлчилгээний зардалд зарцуулагдана. Түүнчлэн Сургууль нь сурагчдын эрүүл мэндийн болон эмнэлгийн хангамжийг сайжруулах, ногоон технологийг ашиглах, хөгжүүлэх замаар бүс нутгийнхаа байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг багасгах зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ. Капитал хөгжүүлэх хураамжийг дараах ажлуудад зарцуулах бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй болно. Үүнд:

- Технологийн гүнзгийрүүлсэн сургалтыг дэмжих технологийн шинэчлэл бүхий ухаалаг анги танхим;
- Мэргэжлийн өндөр түвшний компьютер лабораториуд;
- Контент, контент менежментийн техник хангамжийн талаар суралцах;
- Цахим мэдээллийн хэрэгсэл болон номын сангийн мэдээллийн сангийн хэрэглээ;
- Техник хангамж/програм хангамжийн зайн сургалт;
- Эрүүл мэндийн үзлэг;
- Яаралтай эрүүл мэндийн даатгалын үйлчилгээ;
- Байгаль орчинд мэдрэг технологи болон эрчим хүчний хэмнэлт;
- Хог хаягдлын менежментийн сайжруулсан систем болон дахин боловсруулалт;
- Арга аргачлалыг хэрэглэх замаар хэрэглэгдэхүүн болон үр чадвар олж авах сургалт, мэргэжлийн хөгжүүлэлт;
- Сурагчийн судалгаа, шинжилгээг дэмжих үйлчилгээнүүд;
- Сурагчийн болон байгууллагын мэдээллийг хамгаалах нууцлалын шийдлүүд.

Тухайн жилийн сургалтын төлбөрийн нэгэн адил, технологийн төлбөрийг Төлөөлөн Удирдах зөвлөл тогтоон, баталгаажуулж, тусад нь мэдэгддэг болно.